



## НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

### Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Зөвшөөрөл олгох тухай” 367 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/1059 дүгээр захирамж, “Газрын дүрэм”-ийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн 367 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосон төрийн захиргааны 22 албан тушаалын тодорхойлолтыг баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийн дагуу ажлаа мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (С.Оюунцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2020 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/62 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН